

“ШҮЛЭГЛЭЛТ НОМ”-ЫН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТУХАЙД ЦУХАС ӨГҮҮЛЭХҮЙ

М.ЧИМЭДЦЭЭ*

Эртний хятадын их сэтгэгч Күнз нангиадын соёл, утга зохиолын сор сонгодог зургаан бүтээлийг эмхэтгэн цуглуулж, ариутган шүүж, бичиж туурвин өвлүүлсэн нь өнөө үед уламжлан ирж, хятадын далай их соёл сэтгэлгээний үнэт өв болон хадгалагдаж байгаагийн нэг нь “Шүлэглэлт ном” бөлгөө.

Күнз мэргэн ард түмний дунд түгэн тархсан 3000 шүлэг найргаас шилж сонгон, “Шүлэглэлт ном”-ыг бүтээсэн гэдэг.

Хятадын түүхийн тулгар бичигт тэмдэглэснээр, “Шүлэглэлт ном” нь Күнзээс өмнө байсан бөгөөд Күнз түүнийг хураан цуглуулж, ариутган шүүж, эмхлэн цэгцэлж, 305 шүлэг болгон, үг хэллэг, үсэг тэмдгийг найруулан засаж, хэм хэмнэл, хөг аялгууг тохируулан, уянгын болон магтаалын яруу найргийн эмхэтгэл болгон бүтээсэн ажгуу. Тэр үед шүлэг бүхэн хөг дуурсалтай, шүлгийг уншихын хамт аялгуулан дуулдаг байсан гэх агаад “Шүлэглэлт ном” ч хөг дуурсалтай байсан нь он цагийн нугачаанд ихэнх нь үрэгдэж устах эсбөгөөс холилдож будилсан байсныг Күнз сэргээн, бурууг нь засамжлан, байхгүйг нь нөхсөн түүхтэй юм.

“Шүлэглэлт ном”-ын дотор багтсан шүлэг найраг, яруу дуулал нь цаг хугацааны хувьд эртний Инь улсын (Нийтийн он тооллын өмнөх (НОТӨ) XVII-XI зуун) сүүлч, Жоу улсын (НОТӨ XI-256) эхэн үеэс, Хавар Намарын улсын (НОТӨ 770-476) дунд үе хүртэлх маш урт удаан хугацааг хамрах бөгөөд өөрөөр хэлбэл НОТӨ XI-VI зууны үед хамаарагдана. Энэ утгаараа “Шүлэглэлт ном” бол эртний нангиад орны бүхэл бүтэн үеийн дүр төрхийг тусгасан өвөрмөц нэгэн толь мөн гэж хэлж болно.

“Шүлэглэлт ном”-ыг дотор нь “Салхин”, “Яруу”, “Магтуу” хэмээн ангилдаг. “Салхин” гэдэгт өөр өөр ханлиг улсын нутаг орны 160

дуу багтах бөгөөд 15 газар нутгийн ардын дуунаас бүрдэх тул “15 төрийн салхин” хэмээн нэрлэх нь буй. Эдгээр шүлэг дууллыг “Шүлэглэлт ном”-ын охь дээж нь хэмээн үздэг. “Яруу”-г дотор нь “их яруу”, “бага яруу” гэж хуваах бөгөөд “бага яруу” нь ардын болон ордны дуу нийлсэн 74 дуу, “их яруу” нь 31 дуу, нийт 105 дуунаас бүрдэг байна. “Магтуу”-г дотор нь “Жоу улсын магтуу”, “Лу улсын магтуу”, “Шан улсын магтуу” гэж хуваах бөгөөд нийт 40 магтаал дуулал байна. “Шүлэглэлт ном”-ын бөлөг бүр нь сэдэв агуулга, сэтгэл зүйн дүрслэл илэрхийлэл, дүрслэн урласан уран сайхны арга илэрхийллүүдээр тус тусын нэгэн бие даасан зохиол мэт агаад эртний хятадын ард түмний аж амьдрал, ахуй байдал, ажил хөдөлмөр, зан үйл, тахилга тайлга, хорвоо дэлхийн юмс үзэгдэлд хандах хандлага, байгаль ертөнц, өвс ургамал, ан амьтан, жигүүртэн шувуудын зураглал, янаг дурлал, хүний гоо үзэсгэлэнгийн бишрэл, дүрслэл, хүмүүн хоорондын харилцааны учир шалтгаан, уур хилэн, өршөөл нигүүсэл, үзэн ядахуй, энэрэн хайрлахуй, санан мөрөөдөхүй сэтгэл, энэ бүхнийг яруу тод тусган илэрхийлснээрээ уран зохиолын хосгүй гайхамшигт бүтээл болон мөнхөрсөн түүхтэй юм. Их сэтгэгч Күнз “Шавь нар минь, та нар “Шүлэглэлт ном”-ыг шимтэн юунд эс сурнам? “Шүлэглэлт ном”-ыг уншваас сэтгэж, ажиглаж, хоршиж, хорсож чадах буюу. Ойрыг өгүүлвээс эцэг эхээ энэрч, холыг өгүүлвээс хаан эзэндээ шадарлаж чадах, шувуу араатан хийгээд өвс модны нэр өдий төдийг тогтоож чадах бөлгөө” [4.118] хэмээн шавь нартаа сургаж, “Шүлэг найраг эс сурваас үг хэрхэн гарах билээ” [4.115] хэмээн хүүдээ захиж, “Шүлэглэлт ном”-ын гурван зуун шүлгийг сурч мэдсэний хойно засгийн хэргийг захируулахуйд эс

*М.Чимэдцээ-МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн багш, доктор (Ph.D)

чадах хийгээд дөрвөн зүгт зарлигаар зарахуйд эзэн мэдэж эс чадваас, эрдэм ном сурсан нь их боловч эрхбиш хэрэглэх газар үгүй буюу” [4. 90] хэмээн эрх хэргэмтэнд сануулж, “... хүмүүн хэрэв “Жоу нань” хийгээд “Шао нань” шүлгийг эс уншваас хана хэрэмд хашигдан зогсох лугаа адил бус уу?” [4. 118] хэмээн зүйрлэн өгүүлж байсан нь энэ хосгүй бүтээлийн үнэ цэнэ, ач тусыг хэр өндөр ихээр үнэлж байсныг илтгэх жишээ юм.

“Шүлэглэлт ном”-ыг дэлхийн олон улс оронд аль эртнээс дуун хөрвүүлэн орчуулж ирсэн байх агаад Орос улсад л гэхэд 1852 онд “Москвагийн хүн” сэтгүүлийн нэгдүгээрт “Шүлэглэлт ном”-ын шүлгүүдээс шилж, орчуулснаа “Күнзийн шүлэг” нэртэй хэвлэж байжээ.

Эртний хятадын өдий төдий сонгодог судар номыг монголын номч мэргэн, эрдэм төгс дуун хөрвүүлэгч, гүүш нар сорчлон шилж сонгон, тансаг сайхан монгол хэлээр дуун хөрвүүлэн орчуулсан байтал, эртний шүлэг дууллын цомирлог “Шүлэглэлт ном”-ын орчуулгын зүйл бидэнд уламжилж ирсэнгүй, орчуулж байсан тухай мэдээ занги ч ховор хомс байна.

Эрдэмтэн зохиолч, орчуулагч, миний номын багш Ц. Базаррагчаа “Шүлэглэлт ном”-ын сор дээж 70 шүлэг дууллыг монголчлон, 1999 онд “Шүлэглэлт ном” хэмээх бэсрэг ном хэвлүүлснээр энэхүү сонгодог бүтээлийн шилдэг шүлэг дууллыг эх хэлээрээ амтархан үзэх боломжтой болж, уншигч судлаачдын “оюуны цөгцөнд найргийн шар тос нэмсэн” [2. 3] буянтай үйл болсон юм.

“Шүлэглэлт ном” гээд нэрий нь аль хэдийнээ орчуулан, бичиг зохиолд олонтаа тэмдэглэсэн атал, уг номыг өдий болтол монголчлон орчуулаагүйн хамаг учир нь нэгд, “Шүлэглэлт ном” эртнийхээ бичгээр байгаа, хоёрт, шүлэг орчуулах нь хүүрнэл зохиолыг бодвол нэн нарийн хууль зүйтэй, манай эртний мэргэдийн орчуулгын онол зарчим нэн хатуу байсантай холбоотой болов уу” хэмээн Ц.Базаррагчаа тэмдэглэжээ.

1958 онд Хятадын эрдэмтэн Юй Гуань Инь “Шүлэглэлт ном”-ын 105 шүлэг дууллыг эртний хятад хэлнээс орчин цагийн хятад хэлнээ хөрвүүлснийг Дэлгэрсан монголчлон, 1985 онд “Шүлэглэлт номын сонгомол орчуулга” нэртэйгээр Бээжин хотноо хэвлүүлжээ.

Эрдэмтэн зохиолч С.Дулам “Дорно дахины уран зохиолын үүд” бүтээлдээ “Шүлэглэлт ном”-ын зарим шүлэг дууллыг

орчуулан эш татаж оруулсан байна.

Эдгээр орчуулга нь эдүгээ “Шүлэглэлт ном”-ын монгол орчуулгын уран чадварын судалгаа шинжилгээнд авч үзэх гол хэрэглэгдэхүүн болж байна.

Ардын аман зохиол нь зан үйлийн яруу найраг, ардын дуу, эртний домог зэрэг олон төрөл зүйлээс бүрдэх бөгөөд төрөл тус бүр нь өөрийн уран сайхны өвөрмөц онцлогтой. Хятадын аман зохиолд зан үйлийн яруу найраг чухал байрыг эзлэх агаад ийм зан үйлд холбогдох олон дуу “Шүлэглэлт ном”-д уламжилж иржээ. Ийм нэгэн шүлгийг монгол хэлнээ хэрхэн орчуулсан жишээг авч үзвэл:

Тэргүүлэгч цэцэг сэм сэмхэн зулгарч
 эхэлмүй
 Тэсч талаас илүүгүй нь зулгараагүй
 байнам
 Тэргүүлэгч цэцэг сэм сэмхээн зулгарч
 эхэлмүй
 Тэн хагасаас илүү нь одоохондоо
 зулгараадүй
 Өлзий төгс өдрийн сайныг алдчих вий
 гэж
 Ураглахыг хүссэн хархүү минь учирлах
 боллоо
 Тэргүүлэгч цэцэг сэм сэмхэн
 зулгарсаар байнамүй
 Тэртэй тэргүй гуравны нэг нь үлдсэн
 баймүй
 Өнөөдрөөс хойш ахиад хүлээж
 чадашгүйн гэж
 Ураглахыг хүссэн хархүү минь учирлах
 боллоо.
 Тэргүүлэгч цэцэг сэм сэмхэн
 зулгарсаар байнамүй
 Тэвэр тэврээр болц нь ханасан жимсий
 нь түүнэмүй
 Тэгэхээр одоо нэг ам нээх болсон биш
 үү гэж гуйнамуй. [2. 38]

Нэгэн гоо бүсгүй ураглахыг гуйн ирэх идэр залуу хоёрын хайр сэтгэлийн өрнөлийг тэргүүлэгч цэцэг хагдарч зулгарах, үр жимс нь боловсрох цаг хугацааны учир шалтгааны холбоонд оруулан шүлэглэснийг ийнхүү уран яруу орчуулжээ. Энд монгол шүлгийн онцлогийг харгалзан, толгой холбох зорилгоор чимэг үг оруулан, шүлгийн аяс айзмыг жигдрүүлэх, сэтгэл хөдлөлийн чадлыг нэмэгдүүлэхийн тулд холбоо үг хэрэглэх, үг давтах зэргээр үгсийн сангийн

бүрнээ орчуулах хэрэгтэй. ...Мөн тэрчлэн нэг үгийг ямагт нэг үгээр орчуулахад их л бэрхтэй, хэд хэдэн үгийг хэрэглэх ба зарим үгийг ондоо үгээр орчуулах ч учир гарна. Гагцхүү утгыг алдахгүйг хичээх хэрэгтэй. Нэг талаас үгийг хэтэрхий баримталбал утгыг алдана. Бас нөгөө талаас үгийг хайхрахгүй ахул уг эхээс хэтэрхий холдож орчуулга гэж танишгүй болно” [1. 282] хэмээн орчуулагч дуун хөрвүүлэгчийн мөрдвөл зохих зарчмыг дурдсан байдаг билээ.

Түүнчлэн энэ шүлгийг орчуулахдаа монгол шүлгийн эн зэрэгцүүлэх ёсыг баримталжээ. “Эн зэрэгцүүлэх ёс монгол шүлгийн тусгай шинж болно. Эн зэрэгцүүлэх ёс адилхан үесийг давтаж хэрэглэх ба холбож хэрэглэхэд гол шалтгаан болохоос гадна шүлгийг ухаж мэдэхэд амархан болгоно” [1. 303] хэмээн үздэг.

Дээрх орчуулгыг ажиглавал, хоёр ба есдүгээр, гурав ба арван нэгдүгээр, зургаа ба арван тавдугаар, долоо ба арван зургаадугаар мөрүүдийг зэрэгцэн адилаар орчуулжээ.

“Монгол шүлгийн мөр нь урт болвол уншихад нуршилтай болох мэт тул эрхбиш богино мөртэй шүлгээр орчуулах” [1.288] чухал байдаг. Академич Ц.Дамдинсүрэн А.С.Пушкиний “Олег цэцний дуулал”-ыг орчуулахдаа хөнгөн амархан шүлэг болгохын тул мөрийг богино болгох, нөгөө талаар утгыг бүрэн бүтэн орчуулахын тул мөрийг урт болгох, ...энэ хоёр зүйлийн үүргийг гүйцэтгэхийн тул нэг мөрийг хоёр мөр болгож орчуулсан [1. 289] туршлагаа өгүүлсэн байдаг. Тэрбээр монгол ардын аман зохиолын дууны шүлэг ихэнхдээ гурван үгт шүлэг байдгийг бас дурдсан билээ.

Ингэж нэг мөр шадыг хоёр мөр болгож орчуулах нь монгол орчуулгын нэн эртний уламжлалт арга зарчим бөгөөд тухайлбал, XIV зууны үеийн их хэлмэрч Шаравсэнгэ төвд эхийн нэг мөрийг хоёр болгохдоо ихэвчлэн мөр бүрд гурав гурван үгтэйгээр шүлгийн хэмжээг тохируулсан байдаг ажээ.

Ц.Базаррагчаа дээрх шүлгийг монголчлохдоо хятад эхийн арван мөрийг арван зургаа болгон мөрийн тоог нэмж, харин мөр тус бүрийн үгийг гурваас дөрвөн үгэнд багтаан орчуулжээ. Тийнхүү мөр

богино, шүлэг хөнгөн болж, ардын аман зохиолд илүү ойртон, унших сонсохуйд яруу сонсголонтой болсон байна. Ингэж орчуулснаар хятад шүлгийн журам төдийлөн эвдэрсэнгүй, үүнийг мөн найман мөр шүлэг болгон уншихад харшлах зүйлгүй байна. Тийнхүү хувиргаж үзвэл:

Аяа! Би гэдэг, Асрын өндөрт аагиж
явлаа.

Аяа! Гэтэл өнөөдрийн өдөр, атгахан
будаагүй өлөн.

Аяа! Хоохой! Аагиж аахилж явсантай
минь

Адилшаах юм огтхон ч алга даа...

Шүлэг орчуулах нь амар хялбар зүйл бус болох нь тодорхой. Тэр тусмаа олон зууны тэртээ зохиогдож ам дамжин уламжилж боловсорч ирсэн ардын аман зохиолын сонгодог шүлэг дууллыг орчуулах нь асар өндөр ур чадвар, хариуцлага шаардана. Академич Ц.Дамдинсүрэн “...сайхан шүлгийг монголчлохдоо бас монгол хэлний шүлэг зохиох хамаг чадлыг бүрнээр хэрэглэж орчуулах нь орчуулагч хүний зайлж болохгүй ариун үүрэг мөн гэвэл зохино” [1. 307] хэмээн онцлон тэмдэглэсэн билээ.

Доктор, профессор Ц.Базаррагчаагийн “Шүлэглэлт ном”-ын орчуулгаас үзэхэд, уг хятад эхээс нь хазайлгалгүйгээр, уран сайхнаар шүлэглэн, уг эхийн яруу санаа, уран дүрслэлийг бүрнээ илтгэн гаргахыг хичээхийн хамт, монгол орчуулгын уламжлал, зарчимд бүтээлчээр нийцүүлэн, “монгол хэлний шүлэг зохиох хамаг чадлыг бүрнээр хэрэглэж орчуулахыг” ихэд чухалчилсан нь харагддаг юм.

НОМ ЗҮЙ

1. Дамдинсүрэн.Ц. Бүрэн зохиол. Гутгаар дэвтэр. Оршил тайлбар сэлт ном зүй үйлдэж хэвлэлд бэлтгэсэн Цэдэв.Д. УБ., 2001.
2. Шүлэглэлт ном. Хятад хэлнээс орчуулсан Базаррагчаа.Ц. УБ., 1999.
3. Шүлэглэлт номын сонгомол орчуулга. Дэлгэрсэн орчуулав. Үндэстний хэвлэлийн хороо. 1985.
4. Шүүмжлэл өгүүлэл. Хятад хэлнээс орчуулсан Чимэдцэеэ.М. УБ., 2004.